

“ХЭЛМЭГДСЭН” ШУУДАНГИЙН МАРКИЙН НЭГЭН БАРИМТ

Б.Сарантуяа

Монголын шуудангийн маркийн хөгжил нь манай улсын хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой билээ. Анх 1924 онд манай улсын гаргасан “Элдэв-Очир” марк дэлхийн шуудан харилцаанд орсноос хойш эдүгээг хүртэл 1064 сэдвийн марк, 590 сэдвийн анхны өдрийн дугтуй (АӨД) гарснаас хамгийн анхны хэлмэгдсэн марк бол “Чингис хаан” марк, бас дагалдан гарсан Анхны өдрийн дугтуй юм.

Монголын түүхэнд Хэлмэгдэл хэдэн үе шаттай үргэлжилж нийгмийн бүх л анги давхаргыг хамран манай улсын түүх, ёс заншил, соёл урлагийн хэдэн зууны бүтээл сүйрч, нийгмийн оюун санааны амьдрал, олон ургалч үзэл, үндэс язгуураа гэсэн эх оронч үзэл санааг “үндсэрхэг үзэл” хэмээн хяхан хавчиж байсан. Энэхүү хэлмэгдлийн шуурганд Монгол улсын 63 дахь шуудангийн марк “Чингис хаан” өртөн архивын тавиурт 27 жил дарагдаж байгаад дэлхийн шуудан харилцааны сүлжээнд бүрэн эрхтэйгээр эргэн орж ирсэн түүхтэй билээ.

1962 оны 2-р сарын 14-нд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны тогтоолоор “монгол аймгуудыг нэгтгэж, тулгар төрийг үндэслэн байгуулснаар Монголын түүхэнд дэвшилттэй роль гүйцэтгэсэн” гэж Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойгоор 1962 онд 4 төрлийн нэг цуврал марк гаргахыг Холбооны Яаманд зөвшөөрчээ.

Энэ цаг үеийн тухай “1962 оны 5-р сарын 31-нд болох Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг олон улсын хэмжээнд тэмдэглэхээр зэхэж, Чингисийг манайх хэмээн урд хойд хөршүүд маань мэтгэлцэх ч хандлага гарч болзошгүй аястай байхад эх орон Монгол нь үл мэдэгч болон таг чиг чимээгүй өнгөрөх нь зохисгүй тул манай ШУА, ямар нэг хэмжээгээр тэмдэглэх асуудлыг Намын Төв Хороонд тавиад байсан учир эл асуудлыг шийдвэрлэх ёстой болов. Үүний тулд Төмөр-Очир түүхчидтэй байн байн уулзаж байдлыг тодруулаад, УТТ-ны гишүүдэд учирлан танилцуулж хүчин чармайлт гаргасны дүнд УТТ-ны 58-р тогтоол гарсан юм. Уг тогтоолд Төмөр-Очиороор ахлуулсан комисс байгуулж ажлын төлөвлөгөө баталжээ.

Тэрхүү суут хүний гавьяа зүтгэл, сүр жавхлан, өнөөгийн цаг үеийн үзэл зэргийг багтаан тусгасан илтгэлүүд тавих эрдэм шинжилгээний бага хурал хийх, Чингисийн зурагтай энгэрийн тэмдэг, шуудангийн цуврал марк, ил захидал хэвлүүлж төрсөн нутагт нь дурсгалын хөшөө босгох зэрэг арга хэмжээнүүд тусгагдсан төлөвлөгөө байв” хэмээн Д.Төмөр-Очир “Ард түмнийхээ тусын тулд ...” номд тэмдэглэжээ.




Монгол улсын шуудангийн 63 дахь марк. “Чингис хаан”. Уб., 1962. Зураач Ү.Ядамсүрэн.

Дээрх төлөвлөгөө ёсоор уг маркийг гадаадад хэвлүүлж худалдаанд гаргаснаас хэдхэн хоногийн дараа буцаан татаж, Чингис хааны ойг тэмдэглэх нь "пролетарийн интернационализмыг гутаасан, үндэсний үзлийг дэврээсэн хэрэг болно" хэмээн хориглосон байна.



“Чингис хаан” маркийн Анхны өдрийн дугтуй (АӨД). Монгол улсын 31 дэх АӨД. “Чингис хаан” марк дэлхийн шуудангийн хэрэглээнд орсныг илтгэсэн он, сар, өдөр бүхий дардас, тусгай тамга, дугтуйтай.



“Чингис хаан” маркийн картмаксимум. Монгол улсын анхны картмаксимум, Картмаксимум нь тухайн маркийн утга санаатай ижил сэдвээр гаргасан ил захидлыг хэлдэг. Энэ 2 ил захидлын зураач нь тодорхой бус.

Нэрт цуглуулагч Өлзийн Сэрээтэр “Чингис хаан” шуудангийн марк, анхны өдрийн дугтуй, 2 ил захидлыг авч үлдэж чадсан нь бидний үед хүрч иржээ.

Үндэсний Төв Архивын Холбооны Яамны материалыг үзэж байхад

БНМАУ-ын Холбооны Яамны сайдын 1974 оны 6-р сарын 17-ны өдрийн 173 тоот “Марк зарлага болгох тухай” нууц тушаалд,

384
91
92

**БНМАУ**
ХОЛБООНЫ ЯАМНЫ САЙДЫН
ТУШААЛ

1974 оны 6 дугаар
сарын 17 ны өдөр

№ 173

Улаанбаатар
хот

Нууц

МАРК ЗАРЛАГА. БОЛГОХ ТУХАЙ

МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлө-
гөөний 1970 оны II-р сарын 30-ны 24-р тогтоолыг үндэслэн Чингэс
хааны төрсөний 800 жилийн ойгоор хэвлэгдэн гарсан маркаас
МАХН-ын Төв Хорооны I-р нарийн бичгийн дарга, БНМАУ-ын ардын
их хурлын тэргүүлэгчдийн дарга н.Ю.Цэдэнбалд өөрийн нь хүсэлтээр
3 сери, БНМАУ-д ЗСБНХУ-аас суугаа Элчин сайдын яамны эдийн засги
зөвлөх Александр Иванович Качановт өөрийн хүсэлтээр I сери,
МАХН-ын 16-р их хуралд уригдаж ирсэн Унгарын Ажилчны социалист
намын төлөөлөгчдийн тэргүүн УАСН-ын Төв хорооны Улс төрийн тов-
чооны гишүүн БНУАУ-ын Улсын хурлын дарга н.Антол Апро-д өөрийн
нь хүсэлтээр I серийг олгож зарлага болгохыг Төв шуудангийн
захиргааны дарга /н.Батсүхэд / даалгасугай.

**БНМАУ-ЫН ХОЛБООНЫ ЯАМНЫ**
САЙД

/Д.ГОТОВ /


“МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 1970 оны II-р сарын 30-ны 24-р тогтоолыг үндэслэн Чингэс хааны төрсний 800 жилийн ойгоор хэвлэгдэн гарсан маркаас МАХН-ын Төв Хорооны I-р нарийн бичгийн дарга, БНМАУ-ын ардын их хурлын тэргүүлэгчдийн дарга н.Ю.Цэдэнбалд өөрийн нь хүсэлтээр 3 сери, БНМАУ-д ЗСБНХУ-аас суугаа Элчин сайдын яамны эдийн засгийн зөвлөх Александр Иванович Качановт өөрийн хүсэлтээр 1 сери, МАХН-ын 16-р их хуралд уригдаж ирсэн Унгарын Ажилчны социалист намын төлөөлөгчдийн тэргүүн УАСН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн БНУАУ-ын Улсын хурлын дарга н.Антол Апро-д өөрийн нь хүсэлтээр 1 серийг олгож зарлага болгохыг Төв шуудангийн захиргааны дарга /н.Батсүхэд/ даалгасугай. БНМАУ-ын Холбооны Яамны сайд Д.Готов” хэмээжээ.

МАХН-ын Төв Хорооны I-р нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал дарга маркийг өөртөө аваагүй ч байж мэднэ, ямартай ч энэхүү тушаалаас үзэхэд маркийн алдар хүнд гадаад оронд их л нэртэй, тэр ховор маркийг олж авах сонирхол гадаадынханд их байсан нь тодорхой харагдана. Хэдэн ч удаагийн **Нууц**

тушаалаар “Чингис хаан” марк хил давж гадаад орны төрийн тэргүүн нарын цуглуулгад хүндтэй байр эзэлснийг мэдэхгүй юм.

Монголын шуудангийн марк судлалын анхдагч номын нэг Г.Чулуунгомбо “Монгол марк” 1924-1965 он., (Уб., 1965 он.) номынхоо 38-41-р талд 1962 онд хэвлэгдсэн 8 маркаас зөвхөн “Чингис хаан” маркийг орхиж бусад 7 маркийн зураг тайлбаруудыг хийжээ. “Чингис хаан” марк хэвлэгдээд гуравхан жилийн дараа нийтийн хүртээл болсон энэхүү номд дээрх маркийг ор тас хасаж бичсэн нь тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлага байсантай холбоотой байсан биз ээ.

Цаг тавиун болж байсан 1989 оны нэгэн тушаалыг үзүэл, БНМАУ Холбооны Яамны Сайдын сайдын 1989 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Улсын фондоос марк гаргаж худалдах тухай” 149 тоот тушаалд:



“ 1. БНМАУ-ын Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн Яамны Монгол импекс нэгдлийн 1989 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 1548/15 дугаар бичгийг үндэслэн Япон улсын “Жапан Филателик” нүүст “Чингис хаан” маркийн бүтэн цэвэр сериэс 600-г улсын фондоос гарган худалдахыг Маркийн товчоо /н.Дашицэрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Улсын фондоос худалдах маркийг Холбооны Яамны сайдын 1985 оны 233 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу гүйцэтгэхийг Маркийн товчоо /н.Дашицэрэн/-д даалгасугай. Сайд Б.Баатар” гэжээ.


Харин ардчилал тогтож, шинэ түүхэн нөхцөл байдал буй болсноор “Чингис хаан” маркийг чөлөөтэй зарж худалдаалах боломжтой болсон юм.




1989 оны 7-р сарын 1-нд дэлхийн шуудан харилцаанд эргэн ирсэн “Чингис хаан” марк (засварласан).

“Чингис хаан” маркан дээр латин үсгээр “Chinggis Khan Crownation 1189” гэсэн үгийг латин үсгээр дарж “Монголын нууц товчоо”-ны 750 жилийн ойд зориулж 1989 оны 7-р сарын 1-нд буюу анх хэвлэгдсэнээс нь хойш яг 27 жилийн дараа засварлан гаргасан байна. “Засварласан” гэдэг нь анхны маркан дээр нэмэлт бичвэр, үнийн тоог даран цөөн тоогоор худалдаанд гардаг шуудангийн маркийг хэлдэг бөгөөд энэхүү марк бол Монголын шуудангийн 11 дэх засварласан марк болжээ.

1989 оноос хойш мөн “Чингис хаан” маркийг дахин засварлаж 1999 оны 7-р сарын 15-нд “Есүхэйн Тэмүүжин хаан өргөмжлөгдсөний 810 жилийн ойд. 1189-1999. 810 т” гэж бичжээ. Энэ маркаас хойш сар гаруйхны дараа 1999 оны 8-р сарын 25-наар өдөрлөн дээрх маркан дээр засварласан үгийг доош нь тонгоруулан 2 янзаар бичиж гаргажээ. Дээрх шуудангийн маркууд Монгол Улсын 42, 43 дахь засварласан марк болсон түүхтэй.



“Чингис хааны ном” /марктай/ Монгол шуудан ТӨХК-аас эрхлэн гаргасан. 2013.01.01.



“Чингис хаан” монгол, англи хэлээр гаргасан бэсрэг номын дотор “Чингис хаан” (1962) маркийг хийж тайлбарласан болой.

Хэлмэгдсэн марк цагаатгагдсан үед Үндэсний Төв архивын нэгэн ахмад ажилтан дээрх марктай холбоотой бүх тушаал баримт сэлтийг эмхэтгэж архивын ажилтнуудад үзэсгэлэн гарган үзүүлж байжээ. Хэдхэн жилийн дараа хавтаслаж тушаасан нөгөө үзэсгэлэнгээ үзэх гэтэл хавтастай чигээрээ алга болсон байсан нь “хэлмэгдсэн марк”-ийн хэлмэгдэл дахиад л үргэлжилсний жишээ гэлтэй.

“Чингис хаан” маркийн тухай бичихэд марктай холбоотой хэлмэгдсэн тухайн үеийн МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очирын тухай заавал дурдах хэрэгтэй. Д.Төмөр-Очирын дурсамжийн түүвэр номд түүний нутаг усны багын анд, нэрт цуглуулагч, соёлын гавьяат зүтгэлтэн Ө.Сэрээтэр “... 1940-өөд оны эхнээс тухайн үеийн үзэл суртал, улс төрийн боловсролын тэргүүлэгч нэгэн багшаар Төмөр-Очир гэгч хүн товойн гарсан нь, мөнөөх арван жилийн өмнөх Лүнгийн сургуулийн сурагч том эрдэмтэн,

нам засгийн нэрт зүтгэлтнээр тодрон ид гялалзаж байсан үедээ гэнэтийн бузар гүтгэлгээр бүх албан тушаалаасаа зайлуулагдан цөлөгдөж эцэст нь дайсагнагч хар хүчний гарт хорсолтойгоор хөнөөгдсөн нь нэгэн цагт хамт суралцаж явсан надад төдийгүй, нийт Монголын олон түмэнд юутай хайран, юутай харамсалтай санагдана вэ?!" гэж бичжээ. Хэлмэгдэгсдийн ар гэрийнхэн хэдэн үеэрээ сэтгэлийн гүн шархтай амьдарч байгаа билээ.

Чингис хаан марктай дагалдан гарсан ил захидлын тухай цухас дурдахад, "Түүхэнд үнэн ганц буюу Дарамын Төмөр-Очир" номын хавтсанд хоёр ил захидлын ногоон өнгөтэйг хэвлэсэн нь монгол номын хавтсанд заларсан түүчээлэгч ил захидлуудын нэг болжээ. Германд хэвлэгдсэн монголын түүхийн номын хавтсанд "Улаан Чингис хаан" гэж нэршсэн 1990 оны Чингис хаан 2 блок маркийг хэвлэжээ. Мөн японы Осака Их Сургуулийн монгол хэлний багш профессор Шиотани Шигэки "Монгол хэлний сурах бичиг" (2001 он) номдоо монгол шуудангийн хэд хэдэн маркийг сурах бичгийн заах сэдэвтэйгээ уялдуулан оруулсан байсан нь маш оновчтой шийдэл болсон байдаг.

Чингис хааныхаа маркийг хэлмэгдүүлж байсан тэр цагаас хойш 60 шахам жил өнгөрч өдгөө Чингис хааны хөрөг бүхий марк монголын болоод дэлхийн шуудангийн марканд хүндтэй байрыг эзэлж байна. Монголд төдийгүй дэлхийн олон улсад Чингис хааны дүр бүхий шуудангийн марк удаа дараа хэвлэгдсэн юм.

2004 оны 7-р сарын 11 нд "Чингис хаан" нэртэй 4 нэрийн цуврал марк дэлхий дахины шуудангийн эргэлтэд орсноос хойш "Чингис хаан" (1990), "Чингис хаан 830 жил" (1992), "Чингис хаан" – ОУМУ (Олон Улсын Маркийн Үзэсгэлэн). Тайбей-93, 2 нэрийн маркийн эхний марк (1993), "Чингис хааны баатрууд" 2 цуврал (1997), "Монголын эзэнт гүрэн" 2 цуврал (1997), "Чингис хаан" тарифын марк, (1999) "Их монгол улс – 800 жил-1" (2006), "Их монгол улс – 800 жил-2" (2006), "Чингис хаан" тарифын марк, (2007), Монголын Нууц Товчооны 770 жилийн ойд зориулсан цуврал марк 1, 2 (2010, 2011 он), Их Монгол Улс-805 жил, "Чингис хаан" тарифийн марк (2014), "Их Монгол Улс байгуулагдсаны 810 жил" (2016) маркууд гарчээ.

Мөн монголын их хаад Өгөөдэй, Хубилай, Гүюг, Мөнх, Бат нарт зориулсан шуудангийн маркууд 1997-2016 онуудад гарч Монгол Улсынхаа "нэрийн хуудас" болж дэлхийн бүх улсад илгээгдэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд монгол шуудангийн марк судлалын ном, сайтууд дахь шуудангийн маркийн талаарх зөрөөтэй тайлбар, үг хэллэг, орчуулга, маркийн мэндэлсэн он, сар, өдөр, дугаарлалт, худалдаанд гаргасан огноо, хэвлэгдсэн тоо зэргийг нэг мөрд оруулан цэгцлэх хэрэгтэй байна. Мөн улс орныхоо боловсрол, соёл, шинжлэх ухаан, урлаг уран зохиол, түүхээ таниулахад монголын урлагийн үнэт өв-марк, дугтуй, ил захидлыг өргөнөөр ашиглах, толь бичиг, тайлбар толь зэрэгт маркийн зургийг тайлбартай нь оруулах зэргээр өргөн хүрээтэй судлах сурвалжлах цаг болжээ.

A document on "Repressed" postage stamp

According to the Resolution of the Politburo of the Central Committee of Mongolian Revolutionary Party of 14 February 1962, there released 4 series of postage stamps, 2 post cards and of First Day Cover (FDC) dedicated to the 800th Anniversary of Genghis Khan, however, they were removed from sale and forbidden to be sold. During the period of such prohibition the government leaders of Mongolia and other foreign countries obtained such postage stamps for their private collection in compliance with the "Secret" order of the Minister of Communication of the People's Republic of Mongolia number 173 on "Expenditure of stamps" dated 17 June 1974.

Since July 1989, the time of democratic reforms, marks have been returned to the sale market.

Номзүй

- 1970 оны БНМАУ-ын Холбооны Яамны сайдын тушаалууд
1974, 1989 оны Үндэсний Төв Архивын материалууд
Анхны өдрийн дугтуй., First day covers Mongolia 1958-2019. Ulaanbaatar 2020.
- Балданшош Л.** 2006. *Монгол марк.* Уб.
- Болд Ч.** 2007. *Монгол маркийн түүх.* (1924-2007). Уб.
- Вандандорж Д.** 2014. *Хобби ер бусын ертөнц.* Уб.
- Дашжав Д.** 2019. *Монгол маркийг судлахуй.* Research of Mongolian Stamps. Уб.
- Ловор Г.** 1996. *Хамаг монголын хаан шуудангийн марканд.* Хөдөлмөр. №7.
- Сарантуяа Б.** 2014. *Монгол марк-монголын түүх соёлын үнэт өв.* “Улаанбаатар-Guide to UB lifestyle this is UB” сэтгүүлийн 6 №10. 38-41 тал.
- Sarantuya B.** 2017. *Postage stamps mirror history.* The Mongolian OBSERVER сэтгүүл. № 12 (066) 26-28 тал.
- Түвдэндорж С.** 2018. *БНМАУ-ын шуудангийн Ил захидал (1926-1990) Postcard of the Mongolian Peoples Republic (1926-1990).* Уб.
- Takenory Shimizu. 2004. *Collecting Old Mongolian Postage Stamps.*, Ulaanbaatar
- Дарамын Төмөр-Очир** *Ард түмнийхээ тусын түлд ...* (өгүүлэл, тэмдэглэл, илтгэл, хэлсэн үг, асуултын хариулт, хувийн өргөдөл) 2001. Уб., х-358.
- Түүхэнд үнэн ганц буюу Дарамын Төмөр-Очир.* 2001. Дурсамжийн түүвэр. Тэргүүн дэвтэр. Эмх. Санжмятавын Нинжбадгар. “Урлах эрдэм” хэвлэлийн газар. Уб., 201 х.
- Чимэд-Очир Д.** 2020. *Монгол марк (сонирхогчдын гарын авлага) 1924-2020.* Handbook for Collectors of Mongolian Stamp. Уб.
- Чулуунгомбо Г.** 1965. “*Монгол марк*” (1924-1965). ред. Г.Сүхбаатар. Уб.
- Enkhbat Chuluundorj.** 2013. *Postal history of Mongolia 1848-1937*, Ulaanbaatar
- Энхчимэг Н.** 2017. “*Шуудангийн маркийн үг хэллэгийн толь, тайлбар*” Хэл шинжлэлийн ухааны магистрын зэрэг хамгаалсан зохиол. Уд. Б.Сарантуяа. МУИС-ШУС. Уб., х-70.